



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2023 оны 06 сарын 13 өдөр

Дугаар А/378

Арвайхээр сум

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалт, 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бат-Өлзий сумын Ерөнхий боловсролын сургуулийн Спорт заалын дээврийн засвар үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: Б.Нацаг (аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийтлэг үйлчилгээний албаны дарга)

Гишүүд: Ц.Нямдалай (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын мэргэжилтэн)

Д.Сугар (Иргэний төлөөлөл) (зөвшилцсөнөөр)

Ц.Оюун (Иргэний төлөөлөл) (зөвшилцсөнөөр)

Нарийн бичгийн дарга: Б.Пүрэвсүрэн (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Орон нутгийн өмчийн газрын Худалдан авах ажиллагааны алба Худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн)

2. Худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, мэдэгдэл, гэрээний төслийг өргөн мэдүүлэхийг Үнэлгээний хорооны дарга (Б.Нацаг)-д даалгасугай.

3. Тендер шалгаруулалттай холбоотой баримт бичгээр хууль тогтоомжийн дагуу архивын нэгж бүрдүүлж, Архив, бичиг хэргийн ажилтанд хүлээлгэн өгөхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Б.Пүрэвсүрэн)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

6223 11 0732

D:My Doc. Zahiramj. Zasag darga